

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Татварын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2026/16/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Шинжээч: З.Мөнгөнцэцэг Утас: 7037308 Цахим хаяг: munguntsetsegz@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дугаар баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45058,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.13 № 38

талай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Татварын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Сангийн сайдын 2023 оны 33 дугаар тушаалаар татварын улсын байцаагч нарт олгосон 230,206.5 мянган төгрөгийн үр дүнгийн шагналын зардлыг санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд батлагдсан төсөвт багтаан үр дүнгийн урамшууллыг олгоогүйгээс 12,175.3 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4520050045

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Татварын газар нь 2025 онд 5 зорилт 25 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 96.8 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			-
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		84,498,063.00	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		84,498,063.00	-
3121	Төгрөг		84,498,063.00	-
31211	Төрийн сангийн харилцах		84,498,063.00	-
33	АВЛАГА		116,742.43	58,629,063.00
335	Бусад авлага		116,742.43	-
3333	Татаас санхүүжилтийн авлага		116,742.43	58,629,063.00
35	БАРАА МАТЕРИАЛ		76,576,490.91	75,288,348.70
354	Хангамжийн материал		76,576,490.91	75,288,348.70
35410	Бичиг хэргийн материал		7,519,063.60	7,418,757.61
35420	Аж ахуйн материал		17,645,608.00	17,632,849.00
35440	Түлш, шатах тослох материал		1,050,000.00	-
35450	Барилгын засварын материал		1,971,000.00	1,777,500.00
35470	Бусад хангамжийн материал		48,390,819.31	48,549,242.09
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		161,191,296.34	133,917,411.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		1,034,583,446.64	1,206,477,698.04
392	Биет хөрөнгө		723,583,446.64	895,477,698.04
39201	Барилга, байгууламж, орон сууц		855,934,529.00	855,934,529.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(251,024,795.82)	(288,960,096.27)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		36,500,000.00	375,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(33,452,783.14)	(168,672,142.75)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		308,647,704.72	341,368,904.72
39206	Хуримтлагдсан элэгдэл		(232,753,855.82)	(268,445,802.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		25,654,527.23	45,654,447.23
39208	Хуримтлагдсан элэгдэл		(12,233,527.49)	(15,893,023.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө		64,126,868.00	64,126,868.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(37,815,220.04)	(44,635,985.99)
393	Биет бус хөрөнгө		311,000,000.00	311,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		311,000,000.00	311,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,034,583,446.64	1,206,477,698.04
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,195,774,742.98	1,340,395,109.74
4	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг			175,000.00
4136	Бусад өглөг			17,663,935.58
41363	Татварын өглөг /ТӨҮГ/			4,072,506.08
41364	НДШ -ийн өглөг /ТӨҮГ/			13,591,429.50
4	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН			17,838,935.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР			17,838,935.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ			
51	Засгийн газрын хувь оролцоо		1,195,774,742.98	
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан			
51101	Өмч: - төрийн		820,279,777.00	820,279,777.00
51101	Өмч: - төрийн		820,279,777.00	820,279,777.00
512	Хуримтлагдсан үр дүн		(306,016,269.69)	(179,234,838.51)

51210	Өмнөх үеийн үр дүн		(270,959,561.36)	(306,016,269.69)
51220	Тайлант үеийн үр дүн		(35,056,708.33)	126,781,431.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		681,511,235.67	681,511,235.67
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН		1,195,774,742.98	1,322,556,174.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,195,774,742.98	1,340,395,109.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО			
	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,788,706,300.00	2,677,016,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		2,448,703,800.00	2,293,946,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,448,703,800.00	2,293,946,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		340,002,500.00	383,069,900.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		340,002,500.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		-	373,069,900.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО		45,449,080.00	264,790,504.63
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		45,414,080.00	264,720,504.63
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		45,049,000.00	263,743,894.63
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		365,080.00	976,610.00
120009	Бусад орлого		35,000.00	70,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,834,155,380.00	2,941,807,004.63
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,869,212,088.33	2,815,025,573.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,630,977,264.75	2,757,570,179.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,015,919,188.40	2,214,112,071.56
210101	Үндсэн цалин		906,770,560.11	983,778,243.39
210102	Нэмэгдэл цалин		649,145,221.86	789,421,936.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт		80,536,503.31	94,646,361.93
210104	Урамшуулал		379,466,903.12	346,265,529.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		254,228,350.74	277,001,687.58
210201	Тэтгэврийн даатгал		174,527,890.00	189,704,158.64
210202	Тэтгэмжийн даатгал		20,591,234.12	22,307,936.36
210203	ҮОМШ өвчний даатгал		10,057,251.15	11,008,768.28
210204	Ажилгүйдлийн даатгал		9,805,629.06	10,792,085.03
210205	Эрүүл мэндийн даатгал		39,246,346.41	43,188,739.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		21,377,888.85	24,490,345.03
210301	Гэрэл цахилгаан		8,378,575.65	9,725,434.02
210302	Түлш, халаалт		10,383,916.96	11,098,390.16
210303	Цэвэр, бохир ус		2,615,396.24	3,666,520.85
2104	Хангамж, бараа материалын зардал		28,705,022.20	13,052,663.48
210401	Бичиг хэрэг		8,050,600.00	5,058,077.22
210402	Тээвэр шатахуун		11,290,000.00	3,330,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр		2,500,000.00	2,822,317.26
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		156,500.00	115,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		6,707,922.20	1,727,269.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		49,831,421.60	20,687,350.00
210601	Багаж, техник хэрэгсэл		2,354,000.00	-
210604	Урсгал засвар		47,477,421.60	20,687,350.00
2107	Томиллолт, зочны зардал		20,625,500.00	2,549,000.00
210702	Дотоод албан томиллолт		20,625,500.00	2,549,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		68,806,678.00	69,122,518.63

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		66,847,020.00	67,541,466.64
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		-	461,800.00
210803	Даатгалын үйлчилгээ		903,200.00	117,612.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		105,174.00	160,174.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		44,000.00	43,800.00
210807	Газрын төлбөр		894,964.00	781,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		12,320.00	16,365.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		171,483,214.96	136,554,543.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		56,254,800.00	44,624,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,011,000.00	80,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал		112,217,414.96	91,849,643.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		238,234,823.58	57,455,393.94
2132	Бусад урсгал шилжүүлэг		221,128,949.50	57,418,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		40,735,236.00	-
213208	ХОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		169,493,713.50	47,698,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		10,900,000.00	9,720,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		17,105,874.08	37,093.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		13,938,709.23	27,476.74
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		3,167,164.85	9,617.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		2,869,212,088.33	2,815,025,573.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		(35,056,708.33)	126,781,431.18
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		(35,056,708.33)	126,781,431.18

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,788,706,300.00	2,677,016,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,448,703,800.00	2,293,946,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,448,703,800.00	2,293,946,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	340,002,500.00	383,069,900.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	340,002,500.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	373,069,900.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	46,217,598.00	-
120009	Бусад орлого	46,217,598.00	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,834,923,898.00	2,677,016,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,804,272,300.00	2,761,514,563.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,566,037,476.42	2,645,430,106.06
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,062,243,918.33	2,201,936,763.62
210101	Үндсэн цалин	906,770,560.11	962,485,118.75
210102	Нэмэгдэл	695,469,951.79	808,761,536.65
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	80,536,503.31	94,646,361.93
210104	Урамшуулал	379,466,903.12	336,043,746.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	254,237,961.24	271,396,317.51
210201	Тэтгэврийн даатгал	174,644,632.43	186,222,420.02
210202	Тэтгэмжийн даатгал	20,484,102.19	21,764,207.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,057,251.15	10,740,203.78
210204	Ажилгүйдлийн даатгал	9,805,629.06	10,529,817.46
210205	Эрүүл мэндийн даатгал	39,246,346.41	42,139,668.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,377,888.85	24,490,345.03
210301	Гэрэл, цахилгаан	7,527,270.81	9,725,434.02
210302	Түлш, халаалт	11,235,221.80	11,098,390.16
210303	Цэвэр, бохир ус	2,615,396.24	3,666,520.85
2104	Хангамж, бараа материалын зардал	25,525,000.00	10,629,227.26
210401	Бичиг хэрэг	6,080,000.00	3,593,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,500,000.00	2,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	2,822,317.26
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,000.00	115,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,250,000.00	1,898,010.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,211,050.00	20,617,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,354,000.00	
210604	Урсгал засвар	46,857,050.00	20,617,400.00
2107	Томилолт, зочны зардал	20,625,500.00	2,549,000.00
210702	Дотоод албан томилолт	20,625,500.00	2,549,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,979,358.00	69,106,152.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,032,020.00	67,541,466.64
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	461,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	903,200.00	117,612.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,174.00	160,174.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	43,800.00
210807	Газрын төлбөр	894,964.00	781,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,836,800.00	44,704,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,136,800.00	44,624,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,700,000.00	80,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	238,234,823.58	116,084,456.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	221,128,949.50	57,418,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,735,236.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	169,493,713.50	47,698,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,900,000.00	9,720,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,167,164.85	58,638,680.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,167,164.85	58,638,680.20
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,938,709.23	27,476.74
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,938,709.23	27,476.74
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	2,804,272,300.00	2,761,514,563.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,651,598.00	(84,498,063.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,290,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,290,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	8,290,000.00	-
223001	Бусад хөрөнгө	8,290,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,290,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	22,361,598.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	62,136,465.00	84,498,063.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,498,063.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад цэвэр хөрөнгө/өмч	Хуримтлагдсан үр дүн	Хяналтын бус хувь оролцоо	Нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	-	(270,959,561.36)	-	1,230,831,451.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга						
C03	Залруулсан үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	-	(270,959,561.36)	-	1,230,831,451.31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт						
C05	Хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт						
C06	Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого						
C07	Тайлант үеийн үр дүн				(35,056,708.33)	-	(35,056,708.33)
C08	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	-	(306,016,269.69)	-	1,195,774,742.98
D01	2025 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	-	(306,016,269.69)	-	1,195,774,742.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга						
D03	Залруулсан үлдэгдэл						
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт						
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт						
D06	Хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт						
D07	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз						
D08	Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого						
D09	Тайлант үеийн үр дүн				126,781,431.18		126,781,431.18
D10	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	820,279,777.00	681,511,235.67	-	(179,234,838.51)		1,322,556,174.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Татаас, санхүүжилтийн орлого				
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,315,439,800.00	2,293,936,982.80	(21,502,817.20)	99.1
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,315,439,800.00	2,293,936,982.80	(21,502,817.20)	99.1
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН (I)	2,315,439,800.00	2,293,936,982.80	(21,502,817.20)	99.1
2	Ажиллагчидтай холбогдсон зардал	2,146,636,600.00	2,138,660,557.87	(7,976,042.13)	99.6
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,904,333,900.00	1,904,332,452.67	(1,447.33)	100.0
210101	Үндсэн цалин	961,318,900.00	962,485,118.75	1,166,218.75	100.1
210102	Нэмэгдэл цалин	532,583,300.00	511,157,225.70	(21,426,074.30)	96.0
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	96,155,300.00	94,646,361.93	(1,508,938.07)	98.4
210104	Урамшуулал	314,276,400.00	336,043,746.29	21,767,346.29	106.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	242,302,700.00	234,328,105.20	(7,974,594.80)	96.7
210201	Тэтгэврийн даатгал	165,899,600.00	160,926,053.48	(4,973,546.52)	97.0
210202	Тэтгэмжийн даатгал	19,113,800.00	18,788,164.20	(325,635.80)	98.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,552,000.00	9,252,182.12	(299,817.88)	96.9
210204	Ажилгүйдлийн даатгал	9,547,200.00	9,068,261.11	(478,938.89)	95.0
210205	Эрүүл мэндийн даатгал	38,190,100.00	36,293,444.29	(1,896,655.71)	95.0
	Бараа, үйлчилгээний урсгал зардал	119,784,900.00	106,258,124.93	(13,526,775.07)	88.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,421,600.00	24,490,345.03	(3,931,254.97)	86.2
210301	Гэрэл, цахилгаан	10,410,200.00	9,725,434.02	(684,765.98)	93.4
210302	Түлш, халаалт	14,344,800.00	11,098,390.16	(3,246,409.84)	77.4
210303	Цэвэр, бохир ус	3,666,600.00	3,666,520.85	(79.15)	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,358,300.00	10,629,227.26	(3,729,072.74)	74.0
210401	Бичиг хэрэг	4,786,500.00	3,593,900.00	(1,192,600.00)	75.1
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	2,200,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,992,000.00	2,822,317.26	(169,682.74)	94.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	194,200.00	115,000.00	(79,200.00)	59.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,185,600.00	1,898,010.00	(2,287,590.00)	45.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,447,400.00	1,447,400.00	-	100.0
210604	Урсгал засвар	1,447,400.00	1,447,400.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	5,958,900.00	2,549,000.00	(3,409,900.00)	42.8
210702	Дотоод албан томилолт	5,958,900.00	2,549,000.00	(3,409,900.00)	42.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,518,700.00	67,062,152.64	(2,456,547.36)	96.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,506,200.00	65,497,466.64	(8,733.36)	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	796,500.00	461,800.00	(334,700.00)	58.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,036,900.00	117,612.00	(919,288.00)	11.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,400.00	160,174.00	(226.00)	99.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	43,800.00	43,800.00	-	100.0

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,193,500.00	0.00	(1,193,500.00)	-
210807	Газрын төлбөр	781,400.00	781,300.00	(100.00)	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,000.00	80,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	80,000.00	80,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,018,300.00	49,018,300.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,018,300.00	49,018,300.00	-	100.0
213208	ХОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	47,698,300.00	47,698,300.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,320,000.00	1,320,000.00	-	100.0
	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (II)	2,315,439,800.00	2,293,936,982.80	(21,502,817.20)	99.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Татаас, санхүүжилтийн орлого	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	383,042,423.26
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	373,042,423.26
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	383,069,900.00
210	Ажиллагчидтай холбогдсон зардал	334,672,523.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	297,604,310.95
210102	Нэмэгдэл	297,604,310.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,068,212.31
210201	Тэтгэврийн даатгал	25,296,366.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,976,043.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,488,021.66
210204	Ажилгүйдлийн даатгал	1,461,556.35
210205	Эрүүл мэндийн даатгал	5,846,224.64
210	Бараа, үйлчилгээний урсгал зардал	48,397,376.74
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,170,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,170,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,199,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,199,900.00
	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	383,042,423.26

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 251,653.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлан дахь “тайлант үеийн үр дүн”-г 249,743.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “Санхүүгийн тайлангийн толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад залруулав.
2. Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан автомашины элэгдүүлэх хугацааг 1,909.9 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлыг бууруулан бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 22,910.1 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул 1 төлбөрийн акт, 3 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

1.1 Төлбөрийн акт

1. Төсвийн орлого бүрдүүлэх ажлын хэсэгт ажиллаагүй нягтлан бодогчид 307.8 мянган төгрөгийн ТУБ-ийн үр дүнгийн шагнал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2023 оны 33 дугаар тушаалаар баталсан “Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам”-ын 2.3-т “Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон ... ажлын хэсэгт ажилласан байдлыг үндэслэн үр дүнгийн шагналыг 1.2-т заасан хувиас хэтрүүлэхгүй олгоно” гэж заасантай нийцээгүй тул төлбөрийн акт тогтоож, аудитын явцад барагдуулсан.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд батлагдсан төсөвт багтаан үр дүнгийн урамшууллыг олгоогүйгээс ХХОАТ-т 4,072.5 мянган төгрөг, даатгуулагчаас төлөх НДШ-ийн зардалд 8,102.8 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтыг баримталж, үр дүнгийн урамшууллыг батлагдсан төсөвт багтаан ажиллах

5.2.2 Ахмадын сангийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын ахмад настнуудын амралт, хүлээн авалтыг зохион байгуулахад анхан шатны бүрдэл хангаагүй баримтаар 3,427.0 мянган төгрөг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 4.3-т "Ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, дэмжлэг олгох, ахмадын сангийн гүйцэтгэлийг тайлагнах асуудлыг тухайн байгууллагын санхүүгийн нэгж болон ахмадын хороо хамтран хариуцан гүйцэтгэнэ", "УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга", "Иж бүрэн байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг баримталж, ахмадын сангийн анхан шатны баримт бүрдэл хангаагүй баримтаар зарлагын гүйлгээ хийхгүй байх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

5.2.3 Бараа үйлчилгээний бусад зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайланд онд газрын төлбөрийн зөвлөмжтэй холбоотой бэлтгэсэн 7,000.0 мянган төгрөгийн тараах материалыг бараа материалын дансаар дамжуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", "УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга", "Иж бүрэн байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг баримталж, бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээг хийхгүй байх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээл - лийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үнэ төлбөргүй хүлээн авсан шинэ автомашины элэгдүүлэх хугацааг дутуу тооцоолсон.	1	1,909.9	-	-	1	1,909.9	1	1,909.9	-	-	-	-
Санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгө, нийт өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн дүнг 249,743.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.	1	249,743.1	-	-	1	249,743.1	1	249,743.1	-	-	-	-
Дүн	2	251,653.0	-	-	2	251,653.0	2	251,653.0	-	-	-	-

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн орлого бүрдүүлэх ажлын хэсэгт ажиллаагүй нягтлан бодогчид 307.8 мянган төгрөгийн ТУБ-ийн үр дүнгийн шагнал олгосон байна.	1	307.8	1	307.8	-	-	-	-	-	-	-	-
Батлагдсан төсөвт багтаан үр дүнгийн урамшууллыг олгоогүйгээс ХХОАТ-т 4,072.5 мянган төгрөг, даатгуулагчаас төлөх НДШ-ийн зардалд 8,102.8 мянган төгрөгийн ер төлбөртэй тайлагнасан байна.	1	12,175.3	-	-	-	-	1	12,175.3	-	-	-	-
Ахмад настнуудын амралт, хүлээн авалтыг зохион байгуулахад анхан шатны бүрдэл хангаагүй баримтаар 3,427,000.0 төгрөгийг зарцуулсан байна.	1	3,427.0	-	-	-	-	1	3,427.0	-	-	-	-
Тайланд онд 7,000.0 мянган төгрөгийн газрын төлбөрийн зөвлөмжийн тараах материалыг бараа материалын дансаар дамжуулаагүй, анхан шатны баримт бүрдэлгүй зарцуулсан байна.	1	7,000.0	-	-	-	-	1	7,000.0	-	-	-	-
Дүн	4	22,910.1	1	307.8	-	-	3	22,602.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өмнөх оны аудитаар өрсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 184,664.6 мянган төгрөгийн 3, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 4,752.0 төгрөгийн 1 тушаалыг тус тус мэдээлээгүй байна.	1	189,416.6	-	-	1	189,416.6	-	-
Дүн	1	189,416.6	-	-	1	189,416.6	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1		-	-
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-		-	-
3	ЗГТС	-	-	-	-	-		-	-
4	ТТЗ	-	-	-	-	-		-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-		-	-
	НИЙТ	1	1	-	-	1		-	-